



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/552

Мөрөн сум

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хуулийн этгээд “Мөрөн вилла” ХХК (РД:6421822)-ын хүсэлтийг үндэслэн Мөрөн сумын 7 дугаар багт байршилтай Хийморь-7, 7676 тоот 6712017462 нэгж талбарын дугаартай 4111 м<sup>2</sup>, 7 дугаар багт байршилтай Хийморь-7, 765 тоот 6712015578 нэгж талбарын дугаартай 2289 м<sup>2</sup>, 7 дугаар багт байршилтай Хийморь-7, 7676 тоот 6712016701 нэгж талбарын дугаартай 6534 м<sup>2</sup> үйлчилгээтэй орон сууцны зориулалттай 3 нэгж талбаруудын газруудыг нэгтгэж нийт 12935 м<sup>2</sup> газрыг үлдсэн 25 жилийн хугацаагаар үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/09 тоот захирамжийн хавсралтын 6 дахь заалт, 2021 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн А/317 дугаар захирамжийн хавсралтын 9 дэх заалт, 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн А/281 дүгээр захирамжийн хавсралтын 5 дахь хэсгийг тус тус хүчингүй болгосугай.

3. Газар эзэмшиж байгаа хуулийн этгээд “Мөрөн вилла” ХХК (РД:6421822)-тай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул)-т тус тус зөвшөөрсүгэй.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Р.Машбат)-д үүрэг болгосугай

ДАРГА  П.ЛХАГВАЖАВ



Захирамж-2023

6712011242